

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн, “Налайхын дулааны станц” ТӨХК-иас ирүүлсэн хүсэлтийг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Налайх дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Налайх дүүргийн төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй компани, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.БолорЭрдэнэ/-нд даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 234 дүгээр тогтоол, 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 381 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м ³	1,100
		Төг/Гж	33,041
2	Төсвийн байгууллагын халаалт	Төг/м ³	1,651
		Төг/Гж	33,041
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	6,930
		Төг/м ³	6,912

2. Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф		
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “О”-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	600		
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Халаалтын улиралд	Төг/хүн	2,875
			Халаалтын бус улиралд	Төг/хүн	4,025
		Усны зарцуулалтаар		Төг/м ³	5,000
3	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф				
3.1	40 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	3,000		
3.2	40 м ² -аас 80 м ² талбайтай айл өрх	Төг/сар	5,000		
3.3	80 м ² -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000		